



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/468

Булган сум

Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулал,  
дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” VIII/56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийг сурлага, урлаг, спорт, олимпиадын амжилтаар тэргүүлэн гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн улсын их, дээд сургуульд элсэн суралцагчдад сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулал, дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулал, дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:


Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)  
Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)  
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)  
Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын  
газрын дарга)  
Г.Нансалмаа (Боловсролын газрын Бодлогын  
хэрэгжилтийн хэлтсийн дарга)  
Б.Солонгомаа (Боловсролын газрын Статистик мэдээ,  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч)  
Нарийн бичгийн дарга: М.Солонго (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого  
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010637

3.Сургалтын төлбөрийн тэтгэлэг, урамшуулал, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР